



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан)¹

ХИЙМЭЛ ОЮУН (AI) НЬ “ЗОХИОН БҮТЭЭГЧ” БАЙЖ ЧАДАХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: v. 11.06.2024, Az. X ZB 5/22

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 6 сарын 11-ний өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Патент, барааны тэмдгийн бүртгэлийн газарт (DPMA) патентын мэдүүлэг гаргахдаа “Dabus” (Бүтээлч санааг бие даан гаргаж хөгжүүлдэг төхөөрөмж) гэх хиймэл оюуныг зохион бүтээгчээр бүртгүүлэх хүсэлт гаргасан. Харин Патент, барааны тэмдгийн бүртгэлийн газар зохион бүтээгчээр хиймэл оюуныг бус зөвхөн хүнийг бүртгэх боломжтой гэх үндэслэлээр тус хүсэлтээс татгалзжээ. Нэхэмжлэгч Холбооны патентын шүүх (BPatG) болон Холбооны дээд шүүхэд (BGH) гаргасан гомдолдоо “Dabus” хиймэл оюуныг зохион бүтээгчээр бүртгүүлэхээс гадна ард нь өөрийн нэрийг нэмж хавсарган Патент, барааны тэмдгийн бүртгэлийн газарт бүртгүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Холбооны патентын шүүхээс: Патентын мэдүүлэгт заавал хүний нэрийг тусгах шаардлагатай бөгөөд хиймэл оюуныг зохион бүтээгчээр бүртгэх нь ХБНГУ-ын хуульд нийцэхгүй. Учир нь Патентын тухай хуулийн 6 дугаар зүйл² болон 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу³ зарчмын хувьд зөвхөн хүнийг зохион бүтээгчээр бүртгэж болох бөгөөд хиймэл оюуныг зохион бүтээгч бус харин аливаа бүтээлийг зохион бүтээхэд ашигласан хэрэгсэлд тооцох нь зүйтэй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Холбооны дээд шүүхээс: Европын Патентын Конвенцын 81 дүгээр зүйл⁴, Европын Патентын Конвенцын дүрмийн 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэг⁵ болон

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://juris.bundesgerichtshof.de/cgi-bin/rechtsprechung/document.py?Gericht=bgh&Art=en&az=X%20ZB%205/22&nr=138469>, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² § 6 Absatz PatG

³ § 37 Abs 1 PatG

⁴ Article 81, European Patent Convention (adopted 5 October 1973, entered into force 7 October 1977), European Patent Organisation, <https://www.epo.org/law-practice/legal-texts/html/epc/2020/e/ar81.html>

⁵ Rule 19(1), Implementing Regulation to the European Patent Convention (adopted 5 October 1973, entered into force 7 October 1977), European Patent Organisation, <https://www.epo.org/law-practice/legal-texts/html/epc/2020/e/r19.html>



ХБНГУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу аливаа шинэ бүтээлийг бий болгоход хиймэл оюуныг ашигласан ч энэ нь эрх зүйн субъект биш тул патентын мэдүүлэгт зохион бүтээгчээр бүртгэгдэх боломжгүй. Өөрөөр хэлбэл, зохион бүтээгчээр зөвхөн хүнийг л бүртгэх боломжтой буюу хиймэл оюун нь хүний оролцоогүйгээр аливаа зүйлийг зохион бүтээх боломжгүй гэж дүгнэн Холбооны патентын шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Мөн хиймэл оюун нь зохион бүтээгчийн бүтээлч үйл ажиллагаанд үндэслэсэн эсэх, түүнчлэн ямар нөхцөлд зохион бүтээгч гэж үзэж болохыг цаашид авч үзэх шаардлагатай гэж дүгнэжээ.

---oOo---